



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"МАНДАЛ ЭНЕРГО" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/09/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3.Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол, бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.3.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсарын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт.....	16
5.1 Албан шаардлага.....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



“МАНДАЛ ЭНЕРГО” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Д.ХАДБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № СЭА-2023/09-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь тайлант онд 1,160,771.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,140,953.3 мянган төгрөгийн зардал гарган 19,817.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь тайлант онд халаалтын орлого 1,024,064.2 мянган төгрөг, усны орлого 110,764.9 мянган төгрөг, үйлчилгээ шинжилгээний орлого 2,185.8 мянган төгрөг, худгийн усны орлого 8,365.5 мянган төгрөг, засвар үйлчилгээний орлого 3,763.3 мянган төгрөг, борлуулсан нүүрсний орлого 11,627.3 мянган төгрөг зэрэг нийт 1,140,953.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, төлөвлөгөөг 3.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

СЭА-2023/09-НА-СТА-ОНА

Нийт зардлын гүйцэтгэл 1,140,953.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 36,592.9 мянган төгрөг буюу 3.2 хувиар хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2021.01.01	2022.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,708,691.65	3,559,058.58
1.1.2	Дансны авлага	71,484,678.33	62,968,528.83
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	315,860.04	2,055,069.50
1.1.4	Бусад авлага	9,769,469.44	5,229,622.31
1.1.6	Бараа материал	70,999,445.37	65,444,456.98
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	934,700.00	900,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	155,212,844.83	140,156,736.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	974,671,078.23	999,595,591.55
1.2.2	Биет бус хөрөнгө	59,598,000.00	64,647,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,034,269,078.23	1,064,242,591.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,189,481,923.06	1,204,399,327.75
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	46,253,215.01	35,784,584.01
2.1.1.2	Цалингийн өглөг		427,787.05
2.1.1.3	Татварын өр	9,727,100.85	42,001,995.02
2.1.1.4	НДШ - ийн өглөг		500,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	8,785,303.57	7,542,633.14
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	64,765,619.43	86,256,999.22
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	64,765,619.43	86,256,999.22
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	250,535,268.80	250,535,268.80
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,632,360.38	2,632,360.38
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,037,427,343.73	1,038,079,161.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-165,878,669.28	-173,104,462.56
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,124,716,303.63	1,118,142,328.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,189,481,923.06	1,204,399,327.75

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	992,524,064.60	1,160,770,994.92
2	Борлуулалтын өртөг	839,559,050.76	1,016,429,216.37
3	Нийт ашиг (алдагдал)	152,965,013.84	144,341,778.55
8	Бусад орлого	7,890,909.11	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	115,706,517.55	107,458,467.54
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	3,628,930.29	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(8,524,956.72)
17	Бусад ашиг (алдагдал)	2,101,810.00	(8,340,382.51)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	39,418,665.11	20,017,971.78
19	Орлогын татварын зардал	3,941,866.51	200,179.71
20	Татварын дараах ашиг (алдагдал)	35,476,798.60	19,817,792.07
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	35,476,798.60	19,817,792.07
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,087,529,569.34	(201,355,467.88)	1,139,341,730.64
Залруулсан үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,087,529,569.34	(201,355,467.88)	1,139,341,730.64
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	35,476,798.60	35,476,798.60
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,037,427,343.73	(165,878,669.28)	1,124,716,303.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(16,400,545.77)	-16,400,545.77
Залруулсан үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,037,427,343.73	(182,279,215.05)	1,108,315,757.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				19,817,792.07	19,817,792.07
Өмчид гарсан өөрчлөлт			651,818.18		651,818.18
Зарласан ногдол ашиг				(10,643,039.58)	-10,643,039.58
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,038,079,161.91	(173,104,462.56)	1,124,716,303.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
№	ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,039,133,831.65	1,309,822,240.65
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,038,782,981.65	1,277,329,173.65
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	87,372.00	1,089,775.00
	Бусад мөнгөн орлого	263,478.00	31,403,292.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	980,376,336.83	1,220,818,073.72
	Ажиллагчдад төлсөн	199,308,369.92	284,740,852.41
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	88,446,379.28	82,242,628.10
	Бараа материал худалдан авахад төлсөн	454,545,880.30	447,757,215.86
	Ашиглалтын зардалд төлсөн	99,233,688.56	149,571,055.46
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	34,685,974.00	109,272,173.06
	Татварын байгууллагад төлсөн	77,502,324.48	87,203,496.41
	Бусад мөнгөн зарлага	26,653,720.29	60,030,652.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	58,757,494.82	89,004,166.93
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	61,666,000.00	87,153,800.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,666,000.00	81,213,800.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		5,940,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,666,000.00)	(87,153,800.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,908,505.18)	1,850,366.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,617,196.83	1,708,691.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,708,691.65	3,559,058.58

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт	м/төг	993,431.6	1,024,064.2	30,632.6	103.1
	а/Дулаан түгээлтийн бусад орлого	м/төг	5,000.0	11,627.3	6,627.3	232.5
	б/Ус хангамж, ариутгах татуургын орлого	м/төг	119,446.4	119,130.4	(316.0)	99.7
	Бусад орлого	м/төг	3,315.2	5,949.0	2,633.8	179.4
2	Нийт орлого	м/төг	1,121,193.2	1,160,770.9	39,577.7	103.5
3	Нийт зардал	м/төг	1,104,360.3	1,140,753.0	36,392.7	103.3
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	131,106.0	107,458.5	(23,647.5)	82.0
4	Татварын өмнөх ашиг	м/төг	16,832.9	20,017.9	3,185.0	118.9
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	15,149.6	19,817.8	4,668.2	130.8
6	Төсвийн төлбөр	м/төг			-	
	а/Орлогын татвар	м/төг	2,866.6	2,001.5	(865.1)	69.8
	б/НӨАТ	м/төг	1,940.5	19,859.9	17,919.4	1,023.4
	в/НДШ	м/төг	-	500.0	500.0	
	г/ХАОАТ	м/төг	4,404.5	18,039.1	13,634.6	409.6
	д/ҮХЭХАТ	м/төг	515.5	1,234.5	719.0	239.5
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	32.0	29.0	(3.0)	90.6
8	Нийт цалингийн сан	м/төг	348,233.4	311,830.7	(36,402.7)	89.5
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	906.9	896.1	(10.8)	98.8
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг			-	
11	Хөрөнгө оруулалт	м/төг	129,700.7	125,900.5	(3,800.2)	97.1
12	Нийт авлага	м/төг	82,504.6	71,153.2	(11,351.4)	86.2
	Үүнээс: найдваргүй	м/төг			-	
13	Нийт өглөг	м/төг	64,765,619.4	86,256,999.2	21,491,379.8	133.2
	Богино хугацаат өглөг	м/төг	64,765,619.4	86,256,999.2	21,491,379.8	133.2
	Урт хугацаат өглөг	м/төг			-	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь “Мандал сумын төвийн хэсгийн хэрэглэгчдийг ажиллах амьдрах тав тухтай нөхцөлөөр хангаж ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, түгээх,
- Цэвэр ус дамжуулан борлуулах.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 45 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2018 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2018 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм

3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,708.70	3,559.10	1,850.40
Авлага	81,254.20	68,198.10	-13,056.10
Татвар, НДШ-ийн авлага	315.80	2,055.00	1,739.20
Бараа материал	70,999.40	65,444.50	-5,554.90
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	934.70	900.00	-34.70
Үндсэн хөрөнгө	1,034,269.10	1,064,242.60	29,973.50
Нийт хөрөнгийн дүн	1,189,481.90	1,204,399.30	14,917.40
Өр төлбөр	64,765.60	86,257.00	21,491.40
Эздийн өмч	1,124,716.30	1,118,142.30	-6,574.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,189,481.90	1,204,399.30	14,917.40

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,850.4 мянган төгрөгөөр өссөн нь 1,309,822.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,307,971.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 68,198.1 мянган төгрөг болж 13,056.1 мянган төгрөгөөр буурсан нь айл өрх, аж ахуйн нэгжийн халаалт, усны авлага буурснаас голлон шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд дараах авлагууд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Тохилог Хараа ОНӨААТҮГ-ын халаалтын авлага 10,880.3 мянган төгрөг, сантехникийн засвар үйлчилгээний ажлын хөлсний авлага 3,190.2 мянган төгрөг,

- 4 дүгээр сургуулийн усны авлага 15,262.7 мянган төгрөг,
- Айл өрхийн халаалт, усны авлага 4,834.0 мянган төгрөг,
- ААН-ийн халаалт, усны авлага 27,624.8 мянган төгрөг,
- Сантехникийн засвар үйлчилгээний авлага 911.3 мянган төгрөг,
- СӨХ-өөс авах авлага 2,643.0 мянган төгрөг,
- Худгийн картны авлага 830.0 мянган төгрөг,
- Иргэн Отгонбаатараас авах авлага 2,021.8 мянган төгрөг байна.

Татвар, НДШ-ийн авлага 1,739.2 мянган төгрөгөөр өссөн нь ААНОАТ-ын тайлангийн илүү төлөлтөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,444.5 мянган төгрөг болж 5,554.9 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 529,045.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 534,600.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардал 900.0 мянган төгрөг болж 34.7 мянган төгрөгөөр буурсан нь УБТЗ-ын ХНН-д урьдчилж төлсөн нүүрс тээврийн хөлс буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 100,175.8 мянган төгрөгөөр өссөн нь сумын ИТХ-с баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 50,900.0 мянган төгрөгийн халаалтын тогоо, 8,360.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч, 8,652.1 мянган төгрөгийн компьютер, принтер, 6,421.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,940.0 мянган төгрөгийн санхүүгийн “Юникус” программ худалдан авсан, 41,354.7 мянган төгрөгийн дулааны шугамыг өөрийн хөрөнгөөр барьж капиталжуулсан, иргэний хандив тусламжаар 651.8 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон сумын ИТХ-н тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 147 дугаар тогтоолоор 22,103.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Тохилог Хараа ОНӨААТҮГ-т шилжүүлсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 86,257.0 мянган төгрөг болж 21,491.4 мянган төгрөгөөр өссөн нь Шивээ овоо ХК-д өгөх өглөг 31,000.0 мянган төгрөгөөр буурсан боловч татварын өр төлбөр 32,369.7 мянган төгрөгөөр, Критек ХХК-д өгөх нүүрсний өглөг 13,390.8 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 173,104.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,225.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 10,643.0 мянган төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлсэн, 16,400.5 мянган төгрөгийн өмнөх оны татварын акт, алданги төлсөн болон тайлант хугацаанд 19,817.7 мянган төгрөгийн ашигтай тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ний 43 дугаар тогтоолоор “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,121,193.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,104,360.3 мянган

төгрөгөөр, ашгийг 16,832.9 мянган төгрөгөөр тогтоож, хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээнд 129,000.7 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,160,771.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,140,953.2 мянган төгрөгийн зардал гарган, 19,817.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд:

- Халаалтын орлого 1,024,064.2 мянган төгрөг,
- Усны орлого 110,764.9 мянган төгрөг,
- Үйлчилгээ шинжилгээний орлого 2,185.8 мянган төгрөг,
- Худгийн усны орлого 7,130.4 мянган төгрөг,
- Худгийн картын орлого 1,235.1 мянган төгрөг,
- Засвар үйлчилгээний орлого 3,763.3 мянган төгрөг,
- Борлуулсан нүүрсний орлого 11,627.3 мянган төгрөг.

Нийт орлогын гүйцэтгэл 1,160,771.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 39,577.8 төгрөг буюу 3.4 хувиар давж биелсэн нь аж ахуйн нэгж, айл өрхийн халаалтын орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,140,953.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 36,592.9 мянган төгрөг буюу 3.2 хувиар хэтэрсэн нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 19,817.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,668.2 мянган төгрөгөөр давж биелэхэд нийт орлогыг 3.4 хувиар давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 960,996.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,609.9 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Мандал Энерго” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 67 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн боловч бүрэн хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 23 удаа хугацаа хоцроож, 4 удаа огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 16 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Бусад мэдээллийг 28 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь

хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 01/1695 тушаалаар Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж сум, орон нутгийн төр төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг төсвийн хөрөнгөөр “Шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй” байх чиглэл хүргүүлсэн байна.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- 2750 ккал илчлэгтэй нүүрсийг ижил үнэ бүхий 1-р фракцын 3100 ккал өндөр илчлэгтэй, шигшсэн нүүрсээр сольсноор нүүрсний зарцуулалт багассан,
- Төлбөр тооцооны хэрэгсэл болох Смарт Монгол аппликейшнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж цаг хугацаа, бичиг хэргийн зардлыг бууруулан ажилласан,
- Авлагыг 13,056.1 мянган төгрөгөөр бууруулсан,
- Үйл ажиллагааны үр дүнгээр 19,817.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан,

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 42 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар татварын тайланд 6,143.9 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан, шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, төлбөрийн цахим баримттай холбоотой 87,810.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгснөөс шилэн дансанд мэдээлэл дутуу мэдээлсэн зөрчлийг давтан гаргасан байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
----------	---------------------	---------	-------------------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	96,350.0	3	90,210.1	75.0
Нийт дүн	4	96,350.0	3	90,210.1	75.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын нэмэгдсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг мөшгин шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй юм.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулга

Аудитаар нийт 82,783.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд 510.2 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан,
- Дансны авлага дансны үлдэгдлийг 1,166.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Бараа материалын дансны үлдэгдлийг 129.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Өр төлбөр дансны үлдэгдлийг 1,563.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийг 261.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Татварын тайланд 30,645.9 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан,
- Ерөнхий удирдлагын зардлыг 275.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Татвар төлөхийн өмнөх ашгийг 16,139.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Эздийн өмч дансыг 16,114.1 мянган төгрөгөөр бууруулсан,
- Хуримтлагдсан, ашиг дансыг 15,978.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

Аудитаар нийт 9,978.0 мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд тусгагдсан сэлбэг материалын худалдан авалт, зарцуулалтын дүн нь нярвын тайлангаас 9,978.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гөргөх үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланг гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд орлого дутуу тайлагнасан	1	510.2	1	510.2			1	510.2				
Дансны авлага илүү тайлагнасан	1	1,166.4			1	1,166.4	1	1,166.4				
Бараа материал илүү тайлагнасан	1	129.8			1	129.8	1	129.8				
Өр төлбөр илүү тайлагнасан	1	1,563.0			1	1,563.0	1	1,563.0				
Үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан	1	261.0	1	261.0			1	261.0				
Татварын тайланд орлого дутуу тайлагнасан	1	30,645.9	1	30,645.9			1	30,645.9				
Зардал илүү тайлагнасан	1	275.0			1	275.0	1	275.0				
Татвар төлөхийн өмнөх ашгийг илүү тайлагнасан	1	16,139.9			1	16,139.9	1	16,139.9				
Эздийн өмч дансыг бууруулсан	1	16,114.1			1	16,114.1	1	16,114.1				
Хуримтлагдсан ашгийн дутуу тайлагнасан	1	15,978.5			1	15,978.5	1	15,978.5				
Дүн	10	82,783.8	3	31,417.1	7	51,366.7	10	82,783.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайланд орлого зарлага дутуу тайлагнасан	1	9,978.0			1	9,978.0						